



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/244

Чингис хот

Цаг агаарын онц аюултай үзэгдэл байгалийн
гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 2020 оны 862 дугаар “Үүрэг хүргүүлэх тухай”, аймгийн Онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед ажиллах хүн хүч, машин, техникийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллахыг сумдын Засаг дарга, Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 10:00 цагаас тодорхойгүй хугацаагаар орон нутгийн замын хөдөлгөөнийг хязгаарлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Иргэд, малчин өрхийн утасны дугаарыг тодотгон аймгийн Онцгой байдлын газар, Ус цаг уур орчны шинжилгээний албанд хүргүүлэх, сэрэмжлүүлэг мэдээ /багц мессеж/-г олон удаагийн давтамжтай хүргэж ажиллах, болзошгүй, гамшиг ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бүх талын арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА